



# ЭКОСУМ

**БИДЭНД ЯАГААД ОРОН  
НУТГИЙН ЖИЖИГ ТББ-  
УУД ХЭРЭГТЭЙ ВЭ?**



**Иргэдийн оролцоо чуулган**

**02/12/2019**

## **БИДНИЙ ТУХАЙ: ТОВЧХОН**

Экосум нь Хишиг-Өндөр суманд амьдарч буй монгол-франц хосын санаачлагаас төрсөн үр шим юм.

### **Г. НАРАНТУЯА**

Би бага насаа Хишиг-Өндөр суманд өнгөрөөсөн, арван жилээ төгсөөд Улаанбаатар хотод Олон Улсын Харилцаагаар суралцав. Үүний дараа Иерусалем хотод бараг гурван жил амьдарч Ойрхи Дорнод, Ислам судлалаар магистрын зэрэг хамгаалаад эх орондоо эргэн ирэв. Би эртний л хөдөө орон нутагт байнга тулгардаг асуудлуудад шийдэл олж, эх орныхоо хөгжилд хувь нэмрээ оруулах мөрөөдөлтэй байсан. Сүүлд Франц явж Хүмүүнлэгийн Менежер чиглэлээр магистрт ахин суралцаж төгссөн.

### **Г. ПИЭР**

Пиер ажлын гараагаа байгаль орчны инженерээр эхлүүлсэн. Хаа сайгүй үзэгдэх байгаль орчин, нийгэм эдийн засгийн асуудлуудыг ажигласны эцэст Пиер өөрийн үйл хэргийг олон улсын хөгжил, нийтийн эрх ашгийн асуудлуудад чиглүүлэхээр шийдэв. Францад эргэн эрээд Парист IRIS Sup'-ийн Олон улсын төслийн менежментээр магистрт суралцан дипломын ажлаа Монгол улсын бэлчээр-газар тариалангийн аж ахуйн тухай бичиж сургуулиа амжилттай дүүргэв. Дараа нь Парис хотод "Дэлхийн эмч нар" ТББ-ын төв оффист ажиллаж мөн хүнс, хөдөө аж ахуйн бодлогын тухай ном бичих ажилд гол үүрэг гүйцэтгээд энэ ажлынхаа төгсгөлд Нараагийн хамтаар Экосум-ыг байгуулж Хишиг-Өндөрт амьдарч байна.

## **ДЭЛХИЙ ХЯМАРЧ БАЙНА: БИД ЮУ ХИЙЖ ЧАДАХ ВЭ?**

Бидний амьдарч буй дэлхийн өнцөг булан бүрт бүхий л салбарт хямралууд улам олноор гарах боллоо. Хоорондоо нягт уялдаа холбоотой байгаль орчин, эдийн засаг, нийгмийн хямралуудыг өргөн цар хүрээгээр авч үзвэл бидэнд байгаль орчин, нийтийн эрх ашгийг эрхэмлэсэн шинэ нийгэмд шилжих зайлшгүй шаардлага тулгараад байна.

Энэ бүхнийг ажиглаж, ойлгоод бид өөрсдөөсөө энэ шилжилт хөдөлгөөнд бид өөрсдийн хэмжээнд юу хийж, хувь нэмрээ оруулж цаашлаад шийдлүүдийг олж чадах вэ гэж асуусан.

Их олон хүмүүсийн адилаар бид 2 эхлээд эдгээр асуудлуудад төвлөрөн олон жил ажиллаж байгаа томоохон олон улсын ТББ-уудад нэгдэн ажиллахаар шийдэж энэ чиглэлээр бүр сургуульд ч сурч төгссөн. Харин хоёулаа томоохон ТББ-д ажиллаад маш богино хугацаанд “олон улсын хөгжил” гэх арга барилын бэрхшээл, асуудлуудыг олж харсан юм.

# ТОМООХОН ТББ-УУД, ОЛОН УЛСЫН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨРҮҮДЭД ТУЛГАРЧ БУЙ АСУУДЛУУД

Сургуульд сурч байхдаа бас дараа нь олон улсын том ТББ-д ажиллаж байхдаа эдгээр байгууллагуудын хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөртөө баримталж буй “хөгжил”-д хүрэх арга барилд эргэлзэж, хэд хэдэн сул талуудыг харж, тодорхойлсон юм.

## ⇒ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨГДӨХҮЙ

Бидний бодлоор томоохон ТББ-уудад тулгардаг хамгийн эхний том асуудал нь гадны орнуудад ажиллах эрх үүргийн тухай юм. Мэдээж эдгээр байгууллагууд бүгд сайн санааны үүднээс “төсөл хүлээн авагчид”-даа эерэгээр нөлөөлөх зорилготойгоор бас тэдний тусламж зайлшгүй хэрэгтэй гэсэн өөрсдийн арга барилдаа бат итгэлтэйгээр ажлаа явуулдаг. Гэтэл зөвхөн энэ итгэл үнэмшил тусгаар улсад гадны үйл ажиллагаа явуулах үндэслэл болж чадах уу? Өөр өөр түүх соёлтой дэлхийн орнуудад өөрсдийн тодорхойлсон “хөгжил”-ийн загварыг тулгах нь зөв үү? Магадгүй тэд хөгжлийг тэс өөрөөр хардаг бол яах вэ?

## ⇒ ОРОН НУТГИЙН АСУУДЛУУДААС АЛС

Мэдээж “хөгжилд хөтөлөгч”, “төслийн тусламж хүртэгч”-дийн хоорондын алслагдмал байдал томоохон асуудал болдог. Хэдийгээр томоохон ТББ-ууд улам бүрээр илүү судалгаа хийж, дотоодын ажиллах хүчийг илүү авч ажиллуулах болсон ч яг хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүдийг шийдвэрлэхээр зорьж буй асуудлуудыг мэдэхгүй, өөрөө нөхцөл байдалд нь амьдарч үзээгүй гадны өндөр албан тушаалтнууд боловсруулсаар л байна. Орон нутгийн иргэдээс өөр хэн асуудлуудыг гүнд нь ортол мэдэж, өөрсдийн хэрэгцээг тодорхойлж, гарц шийдлүүдийг харж чадах вэ? Хэдий хамгийн сайн сайхныг хүсээд, мэргэжлийн үр чадвартайгаар ажиллаж байгаа ч соёл, түүхийн багахан чухал хэсгийг харж чадалгүй хөтөлбөрөө боловсруулснаар тухайн асуудлыг шийдэх хамгийн зөв гарцыг олж чадахгүй байх эрсдэл өндөр.

## ⇒ ХҮНД СУРТАЛ, УЯН ХАТАН БУС БАЙДАЛ

Томоохон ТББ-уудын хэмжээ, бүтэц нь тэдний хувьд хүчин чадал, нөөц бололцооны давуу тал болдог ч бас нэг талаар сул тал болдог гэж бид харсан. 1990-ээд оноос донор байгууллагууд улам бүрээр шаардлагаа өндөрсгөж эхлэснээр ТББ-ууд өөрсдийн мэргэжлийн үр чадвараа ч улам нэмэгдүүлсээр ирсэн. Ингэснээр тэдний бүтээмж, итгэл даах нь нэмэгдсэн ч үүний хажуугаар улам бүр хүнд суртал, уян хатан бус ажлын орчин бүрдэж эхлэв. Ийнхүү ажлын хатуу нөхцөл нэмэгдэж дасан зохицох хурд багассанаар газар дээр нь төсөл хөтөлбөрт орон нутгийн хэрэгцээ, шаардлагыг хангасан өөрчлөлтүүдийг оруулах бараг боломжгүй болсон. Орон нутгийн иргэдийн оролцоогүй боловсруулсан төслүүдэд энэ асуудал бүр ч их тулгардаг.

## ⇒ **ӨНДӨР ЗАРДАЛ**

Байгууллагууд томорч, мэргэжлийн үр чадвар нэмэгдэхийн хэрээр үйл ажиллагаагаа явуулахад шаардлагатай санхүү ч өндөрсөж эхэллээ. Томоохон ТББ-ууд зөвхөн үйл ажиллагаагаа тогтмол явуулахын тулд асар их хөрөнгийг зарцуулж байдаг. Байгууллагуудын төв оффисууд, гадны улсуудад илгээж байгаа мэргэжилтнүүдийн цалинд газар дээр маш их өөрчлөлтийг хийж болох мөнгө ихээр урсдаг болсон. Санхүүжилт олох зогсолтгүй тэмцэл нь ТББ-ууд зарлагдаж буй төслийн үрэлддэлд зориулан тэдний шалгуурт нийцүүлэн бичих болсноор жинхэнэ асуудлуудаас алслагдах, төсөлд оролцогчдын жинхэнэ хэрэгцээг тойрох гэх мэт алдаанууд ихээр гарах боллоо.

## ⇒ **ГАДНЫ АШИГ СОНИРХЛЫН ХАМААРАЛ**

Олон улсын донор байгууллагуудаас улам бүр хамаарах болсон нь томоохон ТББ-уудын бие даасан байдлыг бууруулж байна. Зарим төсөл хэрэгжүүлэгч байгууллагууд өөрсдийн санхүүгийн эх үүсвэрийг бусад орнууд, олон улсын корпорацуудаар сонгохоос өөр аргагүйд хүрдэг. Ийм байдалд яаж тухайн улсын төсөлд оролцогчдын ашиг сонирхол, эрх үүргийг үргэлж гол зорилгоо хэвээр хадгалж ажиллах вэ? Геополитикийн тоглоом, хүчний тэмцэл, эдийн засгийн ашиг сонирхол, улс төрийн үзэл суртлын өрсөлдөөний нөлөө орж ирэх нь хялбар.

## ⇒ **ЭРГЭЛЗЭЭ ТӨРҮҮЛСЭН ҮР ДҮНГҮҮД**

Олон улсын ТББ-ууд хэдхэн жил үргэлжилдэг төслүүд хэрэгжүүлдэг. Өөрсдийн хүрсэн үр дүнг тогтвортой хадгалахыг байнга хичээдэг ч бүтэлгүйтэх нь элбэг. Урт хугацааны үр дүнг газар дээр нь байнга байж, тасралтгүй хичээж байж л хадгалдаг. Гэтэл үүнийг олон улсын байгууллагууд хийх боломжгүй нь тодорхой. Олон арван жилийн ажиглалт, судалгааны үр дүнд “олон улсын хөгжил”-ийн төсөл хөтөлбөрийн арга барилд эргэлзээ төрөөд удаж байна.

Ийм учраас урт хугацааны хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд орон нутгийн жижиг байгууллагуудыг чадавхжуулж нутгийн иргэдийг бүх үе шатанд оролцуулах нь чухал гэдгийг эргэлзээгүй ойлгосноор Монголын хөдөө “Экосум” ТББ-ыг байгуулахаар шийдсэн юм.

# **ЭКОСУМ**

## **БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙТЛЭГ ЭРХ АШИГТ ТУЛГУУРЛАСАН БИДНИЙ ЭРХЭМ ЗОРИЛГО, ҮНЭТ ЗҮЙЛС**

Экосум өөрийн үндсэн зорилгоо байгаль орчноо хамгаалж, нийгмийн тэгш эрх, эдийн засгийн хөгжлийг хамтад нь дэмжсэнээр Монгол улсын орон нутгийн хөгжилд хувь нэмрээ оруулах хэмээн тодорхойлсон билээ.

Эдгээр гурвын салшгүй холбооны улмаас байгаль орчны доройтлыг сааруулж, хөдөө орон нутгийн хөгжлийг дэмжин хот руу шилжин суурьших хөдөлгөөнийг бууруулах эерэг өөрчлөлтийг эхлүүлэхийн тулд өргөн цар хүрээгээр хамтад нь шийдвэрлэх ёстой юм.

## **ОРОН НУТГИЙН, БИЕ ДААСАН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ЦОГЦ АРГА ЗАМ**

Монгол орон өөрөө орон нутгийн, бие даасан тогтвортой хөгжлийг дэмжих цогц арга барилд тун тохиромжтой юм. Цөөхөн хүн ам, олон салбарласан засаг захиргааны нэгж гэдэг нь угтаа бие биеэсээ бараг хараат бус, ангид суурингууд гэсэн үг юм.

Сум бүр цөөхөн суурьшмал хүн амтай сумын төв, түүнийг тойроод сумын захиргаанд албан ёсоор харьяалалтай нүүдэлч малчин айл өрхүүдээс бүрддэг. Сумуудын алслагдмал зайнаас хамаараад тэдний хоорондын харилцан нөлөөлөл харьцангуй бага.

Ийм учраас нэг салбарыг сонгон өргөн хүрээнд ажиллахын оронд Экосум өөрийн үйл ажиллагаануудыг хэд хэдэн байгаль орчин болон нийгэм-эдийн засгийн асуудлуудыг онцлон цогц арга замаар шийдвэрлэж “Загвар сум” болоход төвлөрүүлэх болно.

Төслийн хоёр дахь үе шатанд тус байгууллагын сумын иргэдтай хамтран бий болгосон загварыг улсынхаа өнцөг булан бүртбайгаа орон нутгийн хүн амд хүргэхийн тулд сурталчлан таниулах, хуулбарлан хэрэгжүүлэх эцсийн зорилготой билээ.



## **ХИШИГ-ӨНДӨР СУМ-МОНГОЛ ОРНЫ ХӨДӨӨ ОРОН НУТГИЙН ДУНДАЖ ТӨЛӨӨЛӨЛ**

Экосум Хишиг-Өндөр ТББ Булган аймгийн Хишиг-Өндөр сумыг сонгон үйл ажиллагаагаа явуулах болсон хоёр үндсэн шалтгаан бий.

Нэгдүгээрт тус байгууллагыг үүсгэн байгуулагчид нь тус сумаас гаралтай бөгөөд одоо тус суманд амьдарч байна. Тиймээс байгууллага маань Хишиг-Өндөр суманд холбоо харилцаа сайтай төдийгүй суманд тулгамддаг асуудлууд болон хүн амын хэрэгцээг сайн мэдэх нь тус байгууллагын зүй тогтол, цаашдын хөгжилд нэн чухал юм.

Хоёрдугаарт, хүн амын хоёрны гурав нь малчин, нийт 3000 гаран хүн амьдардаг энэ сумын бүтэц, геологи, цаг уурын орчин болон нийгэм эдийн засгийн байдал нь дундаж, бусад сумдаас онцгойрон ялгарах зүйлгүй юм.

Ийм энгийн дундаж сумыг орон нутгийн, бие даасан тогтвортой хөгжлийн загвар сум болгож чадвал энэ арга замаар Монгол орны бусад бүх суманд манай төслүүд хэрэгжих бүрэн боломжтой нотолгоо болж чадах бөгөөд энэ нь ч бидний эцсийн зорилго билээ.

## **ИРГЭДИЙН ГАР БИЕ ОРОЛЦООТОЙ ОРОН НУТГИЙН, ТОГТВОРТОЙ ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА**

Монголд үүсч, бүртгэгдсэн Экосум байгууллага өөрийгөө Хишиг-Өндөр сумын иргэний хөдөлгөөн хэмээн тодорхойлдог.

Орон нутгийн хамтрагч байгууллагуудаар дамжуулан түр зуурын төсөл хөтөлбөр хэрэгжүүлдэг Олон улсын сайн үйлсийн байгууллагуудаас ялгаатай нь манай байгууллага үрт хугацаанд үйл ажиллагаагаа тогтвортой явуулах орон нутгийн бүрэлдэхүүн байгууллага болохоор зорьж байна.

Ийм ч учраас сумын хэдхэн иргэдийн төлөөллөөс байгууллага маань бүрдэх бус харин ч аль болох олон нутгийнхаа иргэдийн оролцоотой, шинэ гишүүдээр хүрээгээ тэлсэн, ардчилсан засаглалын загвартай байгууллага болохыг эрмэлздэг билээ. Оролцоог дэмжиж, олныг хамарсан орон нутгийн мэдлэг, чадвар, чадавхыг дэмждэг, нийт олонд үр шимээ өгөх тогтвортой ажлын байруудыг бүтээж чадах тийм л байгууллага болох нь бидний зорилго юм.

## **ТАВАН ГОЛ СЭДЭВТЭЙ**

Орон нутгийн өнөөгийн байдал болон тулгамдаж буй асуудлуудад суурилан Экосум дараах таван салбарт өөрийн төслүүдийг анхааран хэрэгжүүлэх болно.



**ДЭВШИЛТЭТ  
АГРО-ЭКОЛОГИ**



**УЛАМЖЛАЛТ, ТОГТВОРТОЙ  
МАЛ АЖ АХУЙ**



**ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ  
БА ҮНЭ ЦЭНЭ**



**ЭКО БАРИЛГА БОЛОН  
СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧ**



**ОРОН НУТГИЙН ХАРААТ БУС  
БАЙДАЛ, ДАСАН ЗОХИЦОХ ЧАДВАР**

# БИДНИЙ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ХОГНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨСӨЛ, ҮР ДҮНГҮҮД

**ЭКОСУМ-ЫН ЗОРИЛГО НЬ ХИШИГ-ӨНДӨР СУМЫГ ХОГГҮЙ СУМ БОЛГОХЫН ТУЛД ХОГ АНГИЛАЛТ, ДАХИН БОЛОВСРУУЛАЛТЫГ НЭВТРҮҮЛЖ, ҮР АШИГТАЙ, ТОГТВОРТОЙ ХОГНЫ МЕНЕЖМЕНТИЙГ БИЙ БОЛГОХ.**

Экосум байгуулагдсанаас хойш бид ямар асуудалд анхаарлаа хандуулах вэ гэж нутгийн иргэд, удирдлагууд гэх мэт олон эх үүсвэрээс санал авснаар хогны менежмент дээр анхаарлаа хандуулан ажиллаж байна. Бидэнд санхүүгийн эх үүсвэр ховор байсан тул 2019 оноос л богино болон урт хугацааны хамгийн шалгарсан, тогтвортой шийдлийг бий болгоход шаардлагатай бага, дунд оврын машин, дэд бүтцийн ажлуудыг эхлүүлсэн. Гэхдээ олон олон ажлуудыг өөрсдийн хязгаарлагдмал нөөц бололцоогоор явуулаад байгаа тухай товч танилцуулъя.

## НУТГИЙН ИРГЭД, АЛБАН ГАЗРУУДАД МЭДЛЭГ, МЭДЭЭЛЭЛ ОЛГЛР НӨЛӨӨЛЛИЙН АЖЛУУД

Төсөл хэрэгжиж эхлэсэн цагаас орон нутгийн иргэд болон (захиргаа, сургууль, цэцэрлэг, сургууль гм) албан газруудад мэдлэг, мэдээлэл олгох нөлөөлөл, үхүүлгын ажлуудыг явуулсан. Бүтэн жилийн туршид албан болон албан бус үүлзалтууд, олон удаагийн цуглаан, илтгэл яриа хэлбэрээр цөөнгүй ажлуудыг байнга явуулсан.

Мэдлэг мэдээлэл олгож, хуваалцах ажилд зориулж олон бичиг, баримт шинээр үүсгэсэн. Хогийг хэрхэн ангилах, яагаад ангилах хэрэгтэй, хогны менежментийн зохистой загвар зэргийн тухай тараах материал, ханын самбаруудыг бэлтгэж олон нийтийн газрууд, жижиг дэлгүүрүүд, албан байгууллагуудад байрлуулсан. Мөн өөрсдийн вэб хуудсанд хог хаягдлаас үүдэх аюул эрсдлүүд, тэднээс хэрхэн сэргийлэх, хог хэрхэн ангилах, хаана яаж зохистой хаях гэх мэт чухал мэдээллийг агуулсан тусгай хуудас ([www.ecosoum.org/hog](http://www.ecosoum.org/hog)) нээж хуудсаа сурталчилсан. Энэ хуудсанд аль болох олон хүнд хялбараар хүргэх зорилгоор товч бичлэг хийж байрлуулсан нь үр дүнтэй болж чадсан. Энэ бичлэгийг сургуулийн бүх сурагчид, албан газруудын ажилтнуудад үзүүлсэн хогны менежментийн тухай баримтат киног (*Trashed*) монгол хэлэнд хөрвүүлж үзүүлсэн.





## ОРОН НУТГИЙН УДИРДЛАГУУДАЙ ХАМТРАН АЖИЛЛАЖ, ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ

Хогны менежментийг сайжруулах, үүний тулд зөв зүйтэй шаардлагатай арга хэмжээнүүдийг цаг алдалгүй явуулах талаар орон нутгийн удирдлагууд, ЗДТГ-ын эргэн тойронд хийсэн нөлөөллийн ажил албан ёсны хамтран ажиллах гэрээ хүртэл гүнзгийрч чадлаа. Бидэнд итгэх тэдний итгэл нэмэгдэж сумын хогны менежментийн чухал оролцогчдын нэг нь Экосум болоод байна

Сумын удирдлагуудаас орон нутгийн хогны менежментийг сайжруулахад баримтлах бодлого, үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахад Экосум-ын саналыг сонсож, зөвлөгөө хүсч хамтран ажиллах санал тавьж байгаа нь үүний баталгаа юм. Энэ оны сүүлээр хамтран ажиллах албан ёсны гэрээ байгуулснаар хогны менежментийг сайжруулахын тулд шил бутлах машин авах, албан газруудад хог ангилалтыг үр дүнтэй явуулах ажлуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.



## БОХИРДСОН ТАЛБАЙН ЦЭВЭРЛЭГЭЭ

Экосум-ын гол томоохон зорилго нь хогонд дарагдаж бохирдсон бүх талбайг цэвэрлэн чөлөөлж одоогийн ил хогийн цэгийн хэмжээг хамгийн боломжит хэмжээгээр багасгах юм. Үүний тулд цаашид олон нийтийг хамарсан хог цэвэрлэгээний ажлыг улам олноор тогтвортой зохион байгуулна. Харин энэ төрлийн ажлыг байгууллагын сайн дурын ажилтнуудын тусламжтайгаар сумын наадмын дараа амжилттай зохион байгуулсан. Сайн дурын ажилтнууд, сумын хүүхэд залуусын оролцоотойгоор 2019 оны Хишиг-Өндөр сумын наадам ойрын жилүүдэд болсон хамгийн цэвэрхэн наадам болж чадсан.






## ХОГ АНГИЛАЛТ


Хангалттай санхүүгийн эх үүсвэртэй болсны дараа бид сумын төвтэйгөө ойр ангилсан хог хүлээн авч, боловсруулах зориулалтын цэгтэй болохоор төлөвлөж байна. Энэ нь иргэдэд хялбараас гадна байгаль орчинд ээлтэй шийдэл гэж бид тодорхойлсон. Харин тэр хүртэл хогоо гэртээ ангилсан иргэд маань авч ирэх боломжтой түр хог ангилалтын цэгийг өөрсдийн гараждаа бий болгоод олон нийтэд нээлттэй байлгаж байна. Хогоо ангилж эхлэсэн хэд хэдэн өрхийнхөө идэвхитэй оролцоог дэмжихийн тулд бид ийм шийдэл эхлүүлсэн юм.





## ХОГ ДАХИН БОЛОВСРУУЛАЛТ

Зарим төрлийн хуванцарыг дахин боловсруулахын тулд бид олон улсын сайн дурын инженер оюутнуудын тусламжтайгаар хуванцар дахин боловсруулах хоёр бага оврын машиныг өнгөрсөн зун барьсан. Нэг нь хуванцар бутлах, нөгөө нь хайлуулж, хэвэнд цутгаж шахах зориулалттай. Олон туршилтууд явуулснаар хамгийн сүүл наадмын үеэр хэрэглэгдсэн нэг удаагийн 100 орчим шөлний тавгаар маш бат бөх сандал хийсэн байгаа. Сумын иргэдийн хогоо ангилж, хуванцар хаягдлын хэмжээг бууруулах сэдлийг нэмэгдүүлэхийн тулд өөр олон туршилтуудыг хийж, олонд хэрэгтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэхээр бид зорьж байна.




## НЭГ УДААГИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХЭРЭГЛЭЭНЭЭС ТАТГАЛЗАЖ, ТЭДНИЙГ ӨӨР БАЙГАЛЬ ЭЭЛТЭЙ БҮТЭЭГДЭХҮҮНЭЭР ОРЛОХ НЬ

Нэгэнт бий болсон хогийг дахин боловсруулснаас гарч буй хогны хэмжээг эхнээс нь бууруулах хавьгүй үр дүнтэй тул ЭкоСум-ын зүгээс нэг удаагийн бүтээгдэхүүний хэрэглээг багасгаж дахин хэрэглэх боломжтой бүтээгдэхүүнүүдийг сурталчилж байна. Энэ талаар хийсэн бидний эхний ажил сумын цэцэрлэг, эмнэлэгт даавуун улавч тарааж өгөх, нэг удаагийн бүтээгдэхүүний хор үршигийн талаар таниулах байлаа. Дараагийн ажил маань хүүхдийн нэг удаагийн живхийг байгальд ээлтэй угаадаг живхээр солих талаар байх болно.



## ӨРХИЙН ХОГНЫ БҮТЦИЙН СУДАЛГАА

Зөвхөн Хишиг-Өндөр суманд төдийгүй Монгол улсын орон нутгийн өрхийн хогны бүтцийн талаар дутагдаж буй мэдээллийг сайжруулахын тулд сумын төвийн 36 (сумын төвийн хүн амын 10%) өрхийг хамруулсан хогны бүтцийн зуны судалгааг өнгөрсөн зун амжилттай явуулсан байгаа. Энэ судалгаагаар сумын төвийн нэг өрх 7 хоногт дунджаар 3.7кг хог гаргадагаас бараг тал нь (жингээр) шил (27%) болон хуванцар (20%) байна. Судалгааны үр дүнг ахин баталгаажуулах мөн хогны бүтцэд үзүүлэх улирлын нөлөөг (тэр дундаа зуухнаас гарах үнсний хэмжээг) харуулах зорилготой өвлийн судалгааг удахгүй явуулахаар бэлтгэж байна.



## ЖИЖИГ, ОРОН НУТГИЙН ТББ-ЫН СУЛ ТАЛ, ТУЛГАРАХ БЭРХШЭЭЛ

### ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨГДӨХҮЙ

#### ⇒ ОРОН НУТГИЙН ИРГЭД НУТАГТАА

Жинхэнэ ардчилсан нийгэмд бүх эрх мэдэл ард түмэнд байдаг. Жинхэнэ хөгжил дэвшил ч мөн тийм л байх учиртай. Орон нутагт тулгарч буй дотоодын асуудлуудыг тэдгээрийг биеэр туулж мэдэрсэн иргэд, тэдний санаачлан байгуулсан иргэний байгууллагууд өөрсдийн тодорхойлсон хөгжлийн зам, арга барилаар шийдэх ёстой гэж бид бодож байна

### ОРОН НУТГИЙН АСУУДЛУУДААС АЛС

#### ⇒ АСУУДЛУУДЫГ ОЙЛГОЖ, МЭДРЭХ

Орон нутгийн иргэд өөрсдөө санаачлан байгуулсан бол тулгарч буй асуудлууд болон тухай талбарт тулгарч болох асуудлуудыг нэг бүрчлэн мэддэг орон нутгийн жижиг байгууллагууд олон давуу талтай байх нь гарцаагүй. Мөн хамгийн үр дүнтэй, зөв шийдлүүдийг өөрсдийн соёл, онцлогт тулгуурлан олж чадна.

### ХҮНД СУРТАЛ, УЯН ХАТАН БУС БАЙДАЛ

#### ⇒ УЯН ХАТАН, ДАСАН ЗОХИЦОХ ЧАДВАР

Жижиг ТББ-ууд дасан зохицох чадвар маш өндөртэй. Ямар нэг нөхцөл байдал өөрчлөгдөж, богино хугацаанд арга хэмжээ авах шаардлага гарахад газар дээр нь амьдардаг гишүүдтэй тул хамгийн том давуу тал болно.

### ӨНДӨР ЗАРДАЛ

#### ⇒ БАГА ЗАРДАЛ

Гадаадад төв оффисын зардалгүй, гадны мэргэжилтнүүдийн өндөр цалин, барууны хэм хэмжээнд хүрэх амьдрах орчны тав тухыг бүрдүүлэх хангамжийн зардалгүй жижиг орон нутгийн ТББ хамаагүй бага зардалтай. Иймээс олон улсын ТББ-тай харьцуулахад ижил хэмжээний санхүүжилтээр хавьгүй олон төслийг санхүүжүүлэх боломжтой юм.

### ГАДНЫ АШИГ СОНИРХЛЫН ХАМААРАЛ

#### ⇒ ХАРААТ БУС/ДОТООДЫН ХЭРЭГЦЭЭ

Нутгийн иргэд өөрсдийн асуудлуудыг өөрсдийн хүч, нөөц бололцоогоор шийдвэрлэж байгаа тул гадны ашиг сонирхолын нөлөөнд автах эрсдэл маш ихээр буурах нь тодорхой.

### ЭРГЭЛЗЭЭ ТӨРҮҮЛСЭН ҮР ДҮНГҮҮД

#### ⇒ ТОГТВОРТОЙ ҮР ДҮН/ БОТИД ХЭРЭГЦЭЭ

Тухайн орон нутагтаа байнга оршин суудаг тул орон нутгийн иргэний байгууллагууд төсөл хэрэгжиж дуусах эцсийн хугацаанд баригдахгүй, гарсан үр дүнгүүдээ тогтвортой хадгалж, цаашдын хэрэгцээг хангаж, үйл ажиллагаагаа хянах боломжтой юм.

Гэсэн хэдий ч жижиг орон нутгийн ТББ-д асуудлууд тулгарах нь дамжиггүй:

- ⇒ **САНХҮҮЖИЛТ ОЛОХ, АВАХ**
- ⇒ **ҮНДЭСНИЙ ШИЙДВЭР ГАРГАГЧИДТАЙ ХОЛБОГДОХ**
- ⇒ **НАРИЙН МЭДЛЭГ, ЧАДВАР ДУТМАГ**
- ⇒ **ОЛОН УЛСЫН ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨГДӨХ**

## **ДҮГНЭЛТ**

Эдгээр тулгарч болох саад бэрхшээл, сул талуудыг даван туулахын тулд жижиг орон нутгийн байгууллагуудын хамтын ажиллагаа нэн чухал гэж бид үзэж байгаа юм. Хамтдаа бид санхүүгийн эх үүсвэр, үндэсний шийдвэр гаргагч нарт илүү хялбараар хүрэх боломжтой болно. Мөн өөрсдийн хуримтлуулсан мэдлэг, туршлага, чадвараа солилцоход ч илүү хялбар болох юм.

Шилжиж буй энэ шинэ “хөгжлийн зам”-д олон улсын байгууллагууд чухал байр суурь эзлэсэн хэвээр байх нь дамжиггүй. Өөрсдийн мэргэжлийн үр чадвар, мэдлэгийг орон нутгийн оролцогчдыг чадавхжуулж асар их мөнгийг үр ашигтайгаар зарцуулах боломжтой юм. Энэ шинэ байдалд олон улсын ТББ-ууд илүү хурдан дасан зохицох боломжтой. Үүний тулд олон улсын ТББ-ууд орон нутгийн жижиг ТББ-уудыг тэдний боловсруулсан төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэгч биш харин ч өөрсдийн ижил түвшний хамтрагчид бүр цаашлаад бие даасан иргэний нийгмийн хөдөлгөөн гэж харж дэмжлэг, тусламж шаардлагатай үед хамтран ажиллах нь зүйтэй.